



БАТЛАВ. МОНГОЛЫН ДААМЫН ХОЛБООНЫ  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
*Ч.Бат-Эрдэнэ* Ч.БАТ-ЭРДЭНЭ

“ЕБС-ИЙН ЦОМ-2016” УЛСЫН АВАРГА БАГ ШАЛГАРУУЛАХ  
ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

“

**Нэг. Нийтлэг зүйл**

1. 1. Ерөнхий боловсролын сургуулийн “2016 оны даамын улсын аварга баг”-ийг тодруулахад оршино.
1. 2. Тэмцээнд оролцох багийн бүрэлдэхүүн:
  - а. 7-10 насны 2 сурагч (охин, хөвгүүн)
  - б. 11-13 насны 2 сурагч (охин, хөвгүүн)
  - с. 14-16 насны 2 сурагч (охин, хөвгүүн) - Нийт 6 гишүүн
1. 3. Багийн гишүүд бүгд нэг сургуулийн сурагчид байх бөгөөд нэг сургуулиас хэд хэдэн баг оролцож болно.
1. 4. Тэмцээн Монголын даамын холбооны тэмцээний дүрмийн дагуу явагдана.
1. 5. Тэмцээнийг “Индиго” сургалтын төвтэй хамтран зохион байгуулна.

**Хоёр. Тэмцээний журам**

2. 1. Тэмцээн 2016 оны 9 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд явагдана.
2. 2. Тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүнийг Монголын даамын холбоо томилно.
2. 3. Багийн мэдүүлгийг 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл daam@mondaam.mn хаягаар болон www.mondaam.mn сайтаар хүлээн авна. Мэдүүлэгт тамирчдын овог нэр, нас, регистрийн дугаар, дүүрэг, сургууль, спортын цол, багш дасгалжуулагч нарын утасны дугаар зэргийг бичих бөгөөд оролцох тамирчдаа нэгдсэн мэдүүлгээр бүртгүүлнэ.

2. 4. Тэмцээний техникийн зөвлөгөөн 2016 оны 9 дүгээр сарын 23-ны 11.00 цагт СХД-ийн 42 дугаар сургууль дээр явагдана. Техникийн зөвлөгөөнд ирэхдээ багш дасгалжуулагчид багийн тамирчдын дараах бичиг баримтыг авч ирнэ. Үүнд:

- Сурагчийн хувийн хэрэг
- Багийн мэдүүлэг
- Тэмцээний хураамж 60 000₮ ( баг тус бүр)

2. 5. Тэмцээний цагийн хуваарийг техникийн зөвлөгөөн дээр эцэслэн шийдвэрлэнэ.

2. 6. Тэмцээнийг швейцарь системээр есөн тавил тоглохоор төлөвлөж байгаа бөгөөд Шүүгчдийн зөвлөл тэмцээнд оролцогчдын тоог харгалзан өргийн тоог өөрчлөх эрхтэй.

2. 7. Цагийн хяналт талдаа 1 цаг байхаар төлөвлөж байна. Нэмэгдэх цагаар тоглохоор шийдвэрлэвэл нүүдэл бүрт 3 сек.

2. 8. Багийг хожлын тоогоор цуваагаар байр эзлүүлэн, хожлын тоо тэнцсэн үед дараах шалгууруудыг баримталж дүн гаргана. Үүнд:

- a. Багууд хоорондын тоглолтын харьцаа
- b. Швейцарь системийн коэффициент
- c. Багийн бүх гишүүдийн хожлын онооны нийлбэр

### **Гурав. Шагнал, урамшуулал**

3. 1. Эхний гурван байрт шалгарсан багийг цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

3.2. Ширээний аварга тамирчин шалгаруулж дурсгалын зүйлээр урамшуулна.

Холбоо барих Д.Чойжилсүрэн 9916-4205

Email: daam@mondaam.mn Website: www.mondaam.mn